



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/07

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Булган аймгийн мэргэжлийн хяналтын газар" (РД:9012478)-ийн Булган сум 5 дугаар баг Л.Энэбишийн 2 дугаар гудамж 215 тоотод байршилтай 6308003496 нэгж талбар бүхий албан конторын зориулалтаар эзэмшиж буй 4096 м² газрыг Засгийн газрын "Үл хөдлөх эд хөрөнгө балансаас балансанд шилжүүлэх тухай" 2023 оны 109 дүгээр тогтоолын дагуу 2048 м² газрыг "Мал эмнэлгийн газар" (РД:3196879)-т, 2048 м² газрыг "Стандарт хэмжил зүйн хэлтэс" (РД:9011676)-т тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Мал эмнэлгийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/555 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

